

# ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/150НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
www.dornogovi@audit.gov.mn  
Дорноговь аймаг Сайншанд сум  
2024 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий  
Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn  
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр  
Утас: 70523020 Цахим хаяг:  
oyuntulkhuur.u@audit.gov.mn  
Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал  
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com  
Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал  
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2024.02.23 № 1-6/254

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

САЙНШАНД СУМЫН ХҮҮХДИЙН  
4-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт, хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

Сайншанд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байршуулах ёстой мэдээллийг тулган шалгахад Хөрөнгө мөнгө

010000069

зарцуулахтай холбоотой гарсан 2 тушаалыг хугацаа хоцроосон, 2, 3, 5, 8, 11-р саруудад шилэн дансанд мэдээлэл байгаа мэт агуулга буруу тайлан илгээсэн байна.

Ебаримт- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 32 ширхэг 46.7 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 6 ширхэг 10.5 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 85.6 хувийн биелэлттэй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүдэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>64,999,280.23</b>	<b>122,335,594.78</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>14,432,375.03</b>	<b>67,597,471.78</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>14,432,375.03</b>	<b>67,597,471.78</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>14,432,375.03</b>	<b>67,597,471.78</b>
31211	Төрийн сангийн харилцах	9,742,613.18	53,903,305.93
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	4,689,761.85	13,694,165.85
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>50,566,905.20</b>	<b>54,738,123.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,719,200.00</b>	<b>1,804,200.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	1,082,200.00	1,082,200.00
35130	Эм боох материал	637,000.00	722,000.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>48,847,705.20</b>	<b>52,933,923.00</b>
35410	Бичиг хэргийн материал	639,305.00	916,305.00
35420	Аж ахуйн материал	42,669,288.00	45,647,788.00
35450	Барилгын засварын материал	1,508,450.00	1,505,150.00
35460	Хүнсний материал	2,838,262.20	3,914,180.00
35470	Бусад хангамжийн материал	1,192,400.00	950,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>494,922,517.05</b>	<b>756,815,631.71</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>494,922,517.05</b>	<b>756,815,631.71</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>451,208,642.26</b>	<b>713,217,256.92</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	470,218,358.35	765,975,941.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	-58,483,483.80	-81,803,107.08
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	37,951,430.00	34,971,430.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,098,048.39	-21,049,153.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,298,858.00	26,948,858.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,550,699.13	-12,634,426.59
39214	Бусад үндсэн хөрөнгө	647,965.23	489,882.23
39215	Хуримтлагдсан элэгдэл	-416,131.00	-322,560.00
39217	Ном	640,393.00	640,393.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>43,713,874.79</b>	<b>43,598,374.79</b>
39301	Програм хангамж	627,000.00	627,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-433,125.21	-548,625.21
39303	Бусад биет бус хөрөнгө	43,520,000.00	43,520,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>559,921,797.28</b>	<b>879,151,226.49</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>1,229,060.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>1,229,060.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0.00</b>	<b>1,229,060.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	1,229,060.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>559,921,797.28</b>	<b>877,922,166.49</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>559,921,797.28</b>	<b>877,922,166.49</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	186,350,442.87	186,350,442.87
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	186,350,442.87	186,350,442.87
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>356,264,606.41</b>	<b>674,264,975.62</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-190,711,429.02	356,264,606.41
51220	Тайлант үеийн үр дүн	546,976,035.43	318,000,369.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,306,748.00	17,306,748.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>559,921,797.28</b>	<b>879,151,226.49</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>988,062,260.29</b>	<b>864,654,515.69</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>575,310,362.36</b>	<b>295,925,583.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>575,310,362.36</b>	<b>295,925,583.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>4,913,000.00</b>	<b>168,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	168,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	517,838,497.16	295,757,583.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>412,751,897.93</b>	<b>568,728,932.69</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>355,109,800.00</b>	<b>522,856,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	355,109,800.00	522,856,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>210,000.00</b>	<b>0.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>57,432,097.93</b>	<b>45,872,032.69</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,432,097.93	45,872,032.69
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>439,231,053.15</b>	<b>546,654,146.48</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>439,231,053.15</b>	<b>546,654,146.48</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>436,071,053.15</b>	<b>544,154,146.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>283,113,208.17</b>	<b>351,647,725.28</b>
210101	Үндсэн цалин	216,661,009.89	243,359,600.43
210102	Нэмэгдэл	62,130,497.39	100,241,582.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	4,321,700.89	8,046,542.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,526,404.28</b>	<b>44,227,631.20</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,233,355.77	30,183,461.92
210202	Тэтгэмжийн даатгал	2,803,720.69	3,503,934.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,283,710.70	2,816,267.39
210204	Ажилгүйдлийн даатгал	551,060.80	683,198.93
210205	Эрүүл мэндийн даатгал	5,654,556.32	7,040,768.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,074,154.08</b>	<b>43,672,032.69</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,302,186.08	6,470,692.69
210302	Түлш, халаалт	28,682,500.00	31,829,380.00
210303	Цэвэр, бохир ус	7,089,468.00	5,371,960.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,051,530.00</b>	<b>0.00</b>
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>37,430,530.00</b>	<b>57,530,392.20</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	266,210.00
210502	Хоол, хүнс	36,541,030.00	57,264,182.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	889,500.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,212,365.00</b>	<b>2,203,300.00</b>
210604	Урсгал засвар	1,212,365.00	2,203,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>671,000.00</b>	<b>803,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	671,000.00	803,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>36,991,861.62</b>	<b>44,070,065.11</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,770,753.22	7,521,296.77
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,350,800.00	2,684,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,870,308.40	33,864,468.34
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,160,000.00</b>	<b>2,500,000.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,160,000.00</b>	<b>2,500,000.00</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>548,831,207.14</b>	<b>318,000,369.21</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>546,976,035.43</b>	<b>318,000,369.21</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>421,470,159.78</b>	<b>580,401,336.69</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,928,261.85</b>	<b>11,672,404.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	8,928,261.85	11,672,404.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,928,261.85	168,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	313,500.00	168,000.00
120009	Бусад орлого	0.00	11,504,404.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>412,541,897.93</b>	<b>568,728,932.69</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>355,109,800.00</b>	<b>522,856,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	355,109,800.00	522,856,900.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>57,432,097.93</b>	<b>45,872,032.69</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,432,097.93	45,872,032.69
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>407,037,784.75</b>	<b>527,236,239.94</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>407,037,784.75</b>	<b>527,236,239.94</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>403,877,784.75</b>	<b>524,736,239.94</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>285,179,208.17</b>	<b>363,152,129.28</b>
210101	Үндсэн цалин	217,568,010.19	243,359,604.43
210102	Нэмэгдэл	62,759,497.39	111,745,982.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	4,851,700.59	8,046,542.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,526,404.28</b>	<b>44,227,631.20</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,228,784.93	30,183,461.92
210202	Тэтгэмжийн даатгал	2,811,778.35	3,503,934.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,289,096.37	2,816,267.39
210204	Ажилгүйдлийн даатгал	550,238.01	683,198.93
210205	Эрүүл мэндийн даатгал	5,646,506.62	7,040,768.64
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,074,154.08</b>	<b>43,672,032.69</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,302,186.08	6,470,692.69
210302	Түлш, халаалт	28,682,500.00	31,829,380.00
210303	Цэвэр, бохир ус	7,089,468.00	5,371,960.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>29,192,350.00</b>	<b>58,370,600.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	29,192,350.00	58,370,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,194,165.00</b>	<b>2,200,000.00</b>
210604	Урсгал засвар	1,194,165.00	2,200,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>814,000.00</b>	<b>803,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.00	803,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,897,503.22</b>	<b>12,310,846.77</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,149,503.22	9,873,546.77
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,748,000.00	2,437,300.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,160,000.00</b>	<b>2,500,000.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,160,000.00</b>	<b>2,500,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,160,000.00	2,500,000.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>14,432,375.03</b>	<b>53,165,096.75</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>14,432,375.03</b>	<b>53,165,096.75</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	14,432,375.03
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,432,375.03	67,597,471.78

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	186,350,442.87	17,306,748.00	-190,711,429.02	12,945,761.85
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	186,350,442.87	17,306,748.00	-190,711,429.02	12,945,761.85
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	546,976,035.43	546,976,035.43
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,350,442.87	17,306,748.00	356,264,606.41	559,921,797.28
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	186,350,442.87	17,306,748.00	356,264,606.41	559,921,797.28
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	186,350,442.87	17,306,748.00	356,264,606.41	559,921,797.28
18	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	318,000,369.21	318,000,369.21
19	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	186,350,442.87	17,306,748.00	674,264,975.62	877,922,166.49

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>532,767,500.00</b>	<b>478,864,207.25</b>	<b>53,903,292.75</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>532,767,500.00</b>	<b>478,864,207.25</b>	<b>53,903,292.75</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>532,767,500.00</b>	<b>478,864,207.25</b>	<b>53,903,292.75</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>402,916,400.00</b>	<b>363,152,129.28</b>	<b>39,764,270.72</b>
210101	Үндсэн цалин	265,469,600.00	243,359,604.43	22,109,995.57
210102	Нэмэгдэл	128,010,800.00	111,745,982.85	16,264,817.15
210104	Урамшуулал	9,436,000.00	8,046,542.00	1,389,458.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00	0.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>50,570,700.00</b>	<b>44,227,631.20</b>	<b>6,343,068.80</b>
210201	Тэтгэврийн даатгал	34,454,500.00	30,183,461.92	4,271,038.08
210202	Тэтгэмжийн даатгал	4,029,000.00	3,503,934.32	525,065.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,223,200.00	2,816,267.39	406,932.61
210204	Ажилгүйдлийн даатгал	805,900.00	683,198.93	122,701.07
210205	Эрүүл мэндийн даатгал	8,058,100.00	7,040,768.64	1,017,331.36
2105	<b>Нормативт зардал</b>	<b>65,513,100.00</b>	<b>58,370,600.00</b>	<b>7,142,500.00</b>
210502	Хоол, хүнс	65,513,100.00	58,370,600.00	7,142,500.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>812,400.00</b>	<b>803,000.00</b>	<b>9,400.00</b>
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,954,900.00</b>	<b>12,310,846.77</b>	<b>644,053.23</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,517,600.00	9,873,546.77	644,053.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,437,300.00	2,437,300.00	0.00
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>532,767,500.00</b>	<b>523,024,900.00</b>	<b>9,742,600.00</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>522,856,900.00</b>	<b>522,856,900.00</b>	<b>0.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	522,856,900.00	522,856,900.00	0.00
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>9,910,600.00</b>	<b>168,000.00</b>	<b>9,742,600.00</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	9,742,613.18	-9,742,613.18
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	53,903,305.93	-53,903,305.93

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 105,284.9 мянган төгрөгийн 6 зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

*Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 105,284.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчлийн 104,055.8 мянган төгрөгийн зөрчил нь хуулийн хэрэгжилттэй холбоотой байх тул мөнгөн дүнг санхүүгийн тайлангийн аудитын зөрчлөөс хасан тооцож, 1,229.1 мянган төгрөг нь санхүүгийн тайлангийн зөрчилд хамаарч байгаа нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.*

### 5.1 Төлбөрийн акт

2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлээгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Илрүүлэлт1:** Сайншанд сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байршуулах ёстой мэдээллийг тулган шалгахад Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 2 тушаалыг хугацаа хоцроосон, 2, 3, 5, 8, 11-р саруудад шилэн дансанд мэдээлэл байгаа мэт агуулга буруу тайлан илгээсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж1:**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтуудын дагуу тогтмол, хугацаанд нь үнэн зөв мэдээлж хэвших

**Илрүүлэлт 2:** Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 32 ширхэг 46.7 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 6 ширхэг 10.5 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасны дагуу хяналт тавьж арга хэмжээ аваагүй байна. Мөн тохиолдсон байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж 2:* И баримтын дүнг тухай бүрд өөрийн байгууллагын бүртгэлтэй тулгаж бодитоор ажил гүйлгээ гараагүй И баримт гарах тухайн харилцагч байгууллагад мэдэгдэж буцаалтыг баталгаажуулж санхүүгийн бүртгэлдээ үнэн зөв баримтыг тусган ажиллах

**Илрүүлэлт 3:** Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаад 2,3 жил гэсэн хугацаа ашиглагдаж байгаа нь БШУЯ болон түүний харьяа байгууллагуудын мөрдөж буй бодлогын баримт бичигт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаатай тохирохгүй байна.

*Өгсөн зөвлөмж3:* Үндсэн хөрөнгийг НБББББ болон УСНБББОУС-17 “Үндсэн хөрөнгө” бүртгэх зааварт нийцүүлэх бүртгэх, холбогдох хууль, журам, зааврыг хэрэгжүүлэн ажиллах

**Илрүүлэлт 4:** Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд Хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлсөн буюу өмнөх онтой харьцуулбал 38 % иар, нэмэгдүүлсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6 дахь хэсэгт шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх гэж заасныг зөрчиж байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж 4 :* Холбогдох хууль, заавар журмыг мөрдөж ажиллах, зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах

**Илрүүлэлт 5:** Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд богино хугацаат өр төлбөр өсөлттэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж 5:* Холбогдох хууль, заавар журмыг мөрдөж ажиллах, зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах

**Илрүүлэлт 6:** Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1.1-т “Шалгарсан оролцогч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын зургаагаас доошгүй өдрийн дараа, захиалагчаас тогтоосон хугацаанд багтаан гэрээг баталгаажуулж, эх хувиар эсхүл цахим системээр захиалагчид хүргүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж 6:* 10.0 сая-с дээш үнийн дүн бүхий Бараа материал худалдан авахдаа дээрх хуулиудын дагуу худалдан авалтыг хийж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад  
талархал илэрхийлье*

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зөрчлийн байдлын тайланд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд богино хугацаат өр төлбөрийн данс хамгийн өндөр өсөлттэй байсан буюу 1 576 322 төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.	1	1,229.1			1	1,229.1				
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаад 2,3 жил гэсэн хугацаа ашиглагдаж байгаа нь БШУЯ болон түүний харьяа байгууллагуудын мөрдөж буй бодлогын баримт бичигт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаатай тохирохгүй байна	1	-			1					
<b>ДҮН</b>	<b>2</b>	<b>1,229.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>1,229.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/									
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>										
Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байршуулах ёстой мэдээллийг тулган шалгахад Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 2 тушаалыг хугацаа хоцроосон, 2, 3, 5, 8, 11-р саруудад шилэн дансанд мэдээлэл байгаа мэт агуулга буруу тайлан илгээсэн байна.	1	8,322.0							1	8,322.0
<b>ДҮН</b>	1								1	
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>										
Евaгimт- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 32 ширхэг 46.7 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 6 ширхэг 10.5 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.	1	10,355.9							1	10,355.9
Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд Хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлсөн буюу өмнөх онтой харьцуулбал 38 % иар, нэмэгдүүлсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6 дахь хэсэгт шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх гэж заасныг зөрчиж байна.	1	85,377.9							1	85,377.9
Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн байна.	1								1	
<b>ДҮН</b>	3	95,733.8							3	95,733.8
<b>Нийт</b>	4	104,055.8							4	104,055.8